# БАЯНТАЛ СУМЫН 14 ХОНОГИЙН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ



**2023 оны 09 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны хооронд хийгдсэн ажлуудаас**

# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Засаг дарга , Засаг даргын Тамгын газарт ирсэн, явсан, хариутай албан бичиг, өргөдөл гомдолын шийдвэрлэлтийн талаар:

- 1. **Ирсэн албан бичиг -35**
- -Үүнээс: Бүртгэл хяналтын карт хөтөлсөн хариутай албан бичиг -6
- Хугацаандаа явсан хариутай албан бичиг -3
- Хугацаа хоцорсон -3
- Хугацаа болоогүй-3
- 2. **Явуулсан албан бичиг-30**

**3. Өргөдөл, гомдолын шийдвэрлэлт**

**1. Засаг даргад ирсэн өргөдөл-3**

- **ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:**

Өмчлөлийн газраа шилжүүлэхийг хүссэн 1 газрын өргөдлийг хүлээн авч шийдвэрлэн гэрээ гэрчилгээг гарган өгч ажилласан.

1 иргэний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэсэн.

5 иргэний өмчлөлийн материалыг хүлээлгэн өгсөн.

- 2023 оны 08 дугаар сарын 09-ний өдөр бэлчээрийн газрын фотомониторингийн хээрийн тодруулалтын ажлыг хийсэн.
- 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Геодезийн хатуу, цэг тэмдэгтийг хадгалах, хамгаалах ажлын хүрээнд хээрийн хэмжилт тодруулалтыг хийн ажилласан.









# УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын ЗДТГазар, аймгийн БОАЖГазар санаачлан Ойн газраас сумын төвийн салхин дээд талд ойн зурвас байгуулах ажил хийгдэж байна. Тус зурвас газрын хамгаалалтын хашаа нь иргэдийн гаргасан хойноос урагш чиглэсэн шороон замыг хааж байрласан тул тус хэсгүүдэд аюулгүй ажиллагааны тууз, тэмдэгийг байрлуулсан.








# Санхүү төсөв: 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах талаар

Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар тогтоолоор сумын 2023 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулан 1,837,938.1 мянган төгрөгөөр өөрчлөгдөн батлагдсан байна. Үүнд ЕБС, СӨБ, ЗДТГ-ын тогтмол зардалд 31,000.0 мянган төгрөг, Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 241 дүгээр тогтоолоор ЗДТГ-т 62,600.0 мянган төгрөгийг цалин болон ндш, ИТХ-д 9,100.0 мянган төгрөгийг цалин болон НДШ, Мөн ЗДТГ-т нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 2,104.0 мянган төгрөг, тээвэр шатахуунд-1,500.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 396.0 мянган төгрөг нийт 106,700.0 мянган төгрөгийн сумын төсөвт нэмэлт өөрчлөлт оруууллаа.







# Санхүү төсөв: 8 сарын орлогын бүрдүүлэлтийн талаар

2023 оны 08 дугаар сарын 31-ний байдлаар 101.975.3 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 104,944.3 мянган төгрөг буюу 102.9 хувиар орлогыг давуулан биелүүлсэн байна.

Баянтал сумын нэгтгэлийн/ОН/ төлөвлөгөө 1,181,205.5 мянган төгрөг, гүйцэтгэл 870,357.8 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин,унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 271,981.1 мянган төгрөг НДШ 34,307.8 мянган төгрөг зарцуулсан байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 1,952.0 мянган төгрөг , авлага 3,758.5 мянган төгрөг байна. Төсвийн тодотголоор цэвэр бохир усны төлбөр, гэрэл цахилгааны төлбөрийг 100 хувь барагдуулан ажиллаа.



# ХОРШОО ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ТАЛААР:

- Хоршоо хөгжүүлэх сангийн хөнгөлттэй зээлд хамрагдах хүсэлтэй иргэн, ААНБайгууллагуудад төсөл ирүүлэх талаар мэдээлэл байршуулсан.









# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАСГИЙН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймгийн хэмжээнд Монгол Улсад шинжлэх ухааны үндэслэлтэй мал эмнэлэг, үржлийн алба үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг 2023 оны 09 дүгээр сарын 07,08 ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Энэ ойн арга хэмжээний үеэр Баянтал сумаас Хүнс, Хөдөө аж ахуйн яамны тэргүүний ажилтан цол, тэмдэгээр 4 хүн, Говьсүмбэрийн төлөө хүндэт тэмдэгээр 1 хүн, Мал эмнэлгийн ерөнхий газрын хүндэт өргөмжлөлөөр 1 хүн, Сумын Засаг даргын Жуух бичгээр 2 хүн шагнагдлаа.








# БАЙГАЛЬ ОРЧИН :

1. 2023 оны 09-р сарын 14-ний өдөр золбин нохой, муур утгах ажил хийгдсэн. Нийт 27 нохой, 5 муур устгасан. Хойшид устгалын ажил үргэлжлэн хийгдэнэ.
2. Сумын ЗДТГазрын өмнөх 60х60 талбайн цэвэрлэгээний ажил хийгдсэн. Цэвэрлэгээнд Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, Эмнэлэг, ЗДТГ зэрэг байгууллагууд хамрагдсан.
3. 18, 621, 16, 14-р зөрлөгүүдийн хэсэгт байрлах авто зам дагуух хур хог / 7тн/, хогийн цэгүүдийг цэвэрлэсэн. Мөн 14-р зөрлөгийн хэсэгт байрлах хогийн бункер, оо-г сэргээж будсан. Цэвэрлэгээнд Сургууль, Цэцэрлэг, Соёлын төв, эмнэлэгийн төлөөллүүд оролцсон.











# ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ:

## Амбулаторийн үйлчилгээ:

- Нийт үзлэг-85
- Амбулаторийн үзлэг -85
- Үүнээс:
- Идэвхитэй хяналт -0
- Өдрийн эмчилгээ-2
- Гэрийн эмчилгээ-6

  Урьдчилан сэргийлэх үзлэг- 45
- 

## Түргэн тусламжийн дуудлагын төрөл, тоо хэмжээ:

- Нийт дуудлага -15
- Алсын дуудлага -4
- Төвийн дуудлага -11
- Том хүн -11
- Хүүхэд-4
- Осол гэмтэл-0

## Стационарийн үйл ажиллагаа:

- Хэвтэн эмчлүүлэгчид нийт-6
- Дотор -8
- Хүүхэд -3
- Халдварт-0






**Лабораторийн үзлэгийн тоо: 85 /давхардсан тоо/**

# ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ТАЛААР:

1. Жил бүр сумдын ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлдэг “Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ” /ЖГҮ/ 2023 оны 8 дугаар сарын 27-ны өдөр үнэлүүлэв. Энэ жилийн хувьд өмнөх жилүүдийн адилаар “олон нийтийн оролцоо”, “төлөвлөлт”, “ил тод байдал”, “хэрэгжилт”, “хяналт, шинжилгээ-үнэлгээ”, “өмчлөл” гэсэн 6 бүлгийн нийт 35 үзүүлэлтээр ОНХС-ийн үйл ажиллагааг үнэлэв. Мөн ОНХС-гийн талаар Фокус ярилцлага өгөв.

2. 2023 оны 08 дугаар 31-ний өдрийн А/91 дугаар захирамжаар байгуулагдсан ажил хүлээн авах комисс нь “сургуулийн үдийн хоолны ширээ сандал хийх” ажлыг 2023 оны 09-р сарын 01-ний өдөр хүлээн авлаа.











# ХӨДӨӨ АЖ АХУЙН ТАЛААР:

**Намаржилтын ерөнхий нөхцөл байдал:**
Энэ намар 88 малчин, 72 мал бүхий өрхийн 72035 толгой мал намаржиж байна. 2023.09.11 байдлаар 0.55 га талбайгаас 0.3 тн төмс, 1.5 тн хүнсний ногоо хураан авсан дүнтэй байна. Намар цагийн сэрэмжлүүлэг, малчин өрхийн түвшин бэлтгэх өвс тэжээлийн хуваарийг гарган 1-р багийн 12 малчин өрхөд хүргэж, арга зүйн зөвөлгөө өгсөн.Сумын агропаркийн худгийг засварлан ашиглалтад оруулснаар хэвийн ажиллаж байна. Хоёр малчин Төв, Хэнтий аймагт хадланд гарч одоогийн байдлаар 10 тн байгалийн хадлан бэлтгээд байна. Малчин өрхийн түвшинд 1.1 тн үйлдвэрийн тэжээл худалдан авсан.

**Малчдад үзүүлж буй нийгэм, эрүүл мэндийн үйлчилгээ:**
Эрүүл мэндийн төвөөс 12 малчинд эмнэлгийн үйлчилгээ үзүүлсэн. Малчдад худалдаа, үйлчилгээ, шатах тослох материал зардаг ШТС, эрүүл мэндийн төвийн эмч эмнэлэгийн ажилтнууд тухай бүрд нь үйлчилгээ үзүүлж байна. Мөн эмийн сангийн үйлчилгээ, төрийн Е-Монгол хур системийн бүх төрлийн лавлагааны үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

**Малын өвчний байдал, тайван эсэх:**
Малын халдварт, паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг Хилийн дэлгэрэх ХХК технологит хугацаанд нь гүйцэтгэж байна. Одоогоор малын өвчлөл гараагүй тайван байна.Малын өвчнөөс сэргийлэх талаар Баянтал ХААТ группэд 2 удаа сэрэмжлүүлэг хүргэсэн.





# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

**ЕБСургууль:**

1. 2023 оны09дугаар сарын 01-ний өдөр 2023-2024 оны хичээлийн жилийн нээлтийн үйлажиллагаа зохион байгуулагдлаа. Баянтал ЕБС нь 161 сурагч 12 багш 13 ажилтан албан хаагчтай үйл ажиллагаагаа эхлүүллээ.
2. 2023 оны 09 дугаар сарын 04-ний өдөр багш ажилчдын нэгдсэн хурал хийж 2023-2024 оны хичээлийн жилийн төлөвлөлтөө хэлэлцсэн.
3. 2023 оны09дугаар сарын 06 нд Англи хэл, мэдээлэлзүйн багш Г.Энхтунгалаг ГСА-ийн БШУГ-т PEARSON хөтөлбөрийн сургалтад хамрагдсан
4. 2023 оны09дугаар сарын 08 нд сургуулийн Захирал Д.Цэрэнням сургуулийн 25 багш, ажилчдад Боловсролын багц хуулийн багш, суралцагч, асран хамгаалагчийн эрх үүрэг, нийгмийн хамгаалал заалтуудаар сургалт хийлээ.
5. 2023 оны09дугаар сарын 12нд 7-8-р ангийн сурагчдад Өмнөговь аймгийн усны ай сав газраас сургалт хийсэн.Сургалтад 26 сурагч хамрагдсан.









# БОЛОВСРОЛЫН ТАЛААР:

**Сургуулийн өмнөх боловсрол нь:**

1. Боловсролын ерөнхий газраас үндэсний хэмжээнд зохион байгуулсан багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд манай байгууллагаас 2 багш хамрагдан 94,24 болон 90,01 хувиар тус тус үнэлэгдсэн байна. Мөн байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 91,33 хувьтай үнэлэгдэн 3 дугаар шатлалд багтсан байна.
2. 2023 оны 09 дүгээр сарын 13,14-ны өдрүүдэд үндэсний хэмжээнд цахимаар давтан зохион байгуулагдаж байгаа “Бага насны хүүхдийн цогц хөгжил” сургалтанд 2 багш хамрагдаж байна.
3. Нийтийн их цэвэрлэгээнд 8-р сарын 30-нд болон 09 дүгээр сарын 07-ны өдрүүдэд багш, ажилчид гарч байгууллагын гадна орчны 50*50м газрыг цэвэрлэсэн.
4. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган урлаг заал, хүнсний склад, коридор зэргийг замаск татан будаж сэргээсэн. Мөн муудсан сангийн хэрэгслүүдийг бүрэн сольж шинэчилсэн.
5. Сүмбэр 3 бат ариутгалын газартай гэрээ байгуулан байгууллагын дотор ариутгал болон шавьжгүйтлийг 500 М2 талбайд хийлгэсэн.









# СОЁЛ УРЛАГИЙН ТАЛААР:

ХИЙГДСЭН АЖИЛ

1. 9 дүгээр сарын 09-ний өдөр Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Соёлын төв үүсэн байгуулагдсаны 60 жилийн ойн байрт уригдан туршлага судлаад ирлээ. Мөн СУИС-ын соёл судлалын эрдэмтэн багш доктор профессор н.Баатар, Л.Тунгалаг нарыг байгууллага дээрээ урин үйл ажиллагаагаа танилцуулан мэргэжил аргазүйн зөвөлгөө авч ажиллаа.
2. Аймгийн Боржигин-Өв музейгээс 9 дгээр сарын 12-ны өдөр манай байгууллагын ОНСТ-ын ажилтанд чиглэсэн чадвхжуулах сургалтыг зохион байгуулж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаа.







# ТАЛЫН ИЛЧ ОНӨААТҮГазар :

1. Халаалт эхлэхтэй холбогдуулан дулааны шугамд ус шахаж, засвар хийсэн.
2. 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдөр бохирын худгуудыг лайдсан.
3. 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр халаат эхлэх тул 40 тонның нүүрс татан авч бэлтгэл ажлыг хангасан.











***МЭДЭЭНИЙ ЭХИЙГ БЭЛТГЭСЭН ЗДТГАЗРЫН ДАРГА Ц.ЛХАГВАДОНИД***